

Product Data Sheet

Version no: 05/04 (reprinted 08/05)

Sika® MonoTop® 612

Sika® MonoTop® 612

Хялгасан арматуртай бетоны засварын зуурмаг

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika® MonoTop® 612 нь хялгасан арматур агуулсан, полимерээр баяжуулсан, дан бүрэлдэхүүнт бетоны засварын зуурмаг юм. Sika® MonoTop® 612 нь бетоны засвар болон хамгаалалтын MonoTop системд хамаарагдана.

Хэрэглээ:

Sika® MonoTop® 612-ийг өндөр хүчин чадал болон эдэлгээ шаардагдаж байгаа бүтээц болон түүний бүрэлдэхүүн бетонон хийцийн засах болон сэргээн засварлах талбайд хэрэглэнэ. Жишээ нь:

Тусгай төрлийн арчилгаа шаардагдаагүй бүх төрлийн шингэн бетоны арчилгаа, бэхжилтэнд хэрэглэж болно.

- Барилгын гадна фасад
- Багана, дан нурууны засвар
- Бетонон гүүрийн засвар
- Далайн бүтээцийн засвар
- Усан сангийн бүтээцийн засвар
- Цэвэрлэх байгууламжийн бүтээцийн засвар
- Бетонон тунель болон усны хоолойн засвар.

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Зөвхөн ус нэмэх шаардлагатай шууд хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн
- 30 мм хүртэл зузаан түрхэж болно
- Гулзайлтанд өндөр тэсвэртэй учир босоо болон толгой дээгүүрх дүүжин засварт хэрэглэхэд тохиромжтой
- Ажиллах чадвар маш өндөр учир шаардлагатай тохиолдолд зуурмагыг шүршиж хэрэглэж болно.
- Найрлагандаа зэвэрдэггүй хялгасан арматурчлал агуулсан.
- Механик бат бэх сайтай
- Микро цахиурлаг элс болон полимерээр баяжуулсан
- Агшилтанд тэсвэртэй
- Сульфатад тэсвэртэй
- Ус болон хлоридын ионы нэвчилтэнд өндөр тэсвэртэй
- Хоргүй, зэвэрдэггүй

Тест / Стандарт / Зөвшөөрлүүд	LMP – Laboratory of Material Preparation and Methodology, Beinwil, Switzerland – Швейцарь улс, Байнвил хот, Материал боловсруулалт, аргачлалын лаборатори EMPA – Federal Material Testing Laboratory, Dubendorf, Switzerland – Швейцарь Улс. Дубендорф хот, Улсын материалын сорилын лаборатори
--------------------------------------	--

Бүтээгдэхүүний мэдээлэл

Хэлбэр / Өнгө	Цайвар саарал өнгийн нунтаг / Түрхсэний дараа саарал өнгөтэй
Хадгалах нөхцөл / хугацаа	Үйлдвэрээс савлагдсан савлагаанд тагийг нь нээгээгүй тохиолдолд +5°C+25°C хэмийн хуурай сэрүүн орчинд 6 сар хадгалах боломжтой.
Сав баглаа боодол	25 кг-ийн давхар цаасан ууттай байна

Техникийн мэдээллүүд

Нягт (+20°C орчинд)	шингэн зуурмагын нягт ~ 2,1 кг/л
Хэрэглэх үеийн гадаргуун болон орчны температур	+5°C-ээс +30°C-ийн орчинд
Шахалтын бат бэх	28 хоногийн бат бэх ~ 55 МПа (2,8 литр усаар зуурсан тохиолдолд)
Гулзайлтын бат бэх	28 хоногийн бат бэх ~ 9 МПа
Барьцалтын бат бэх	Бетон дээр > 1,5 Мра (бетоны гэмтэлд)
Уян налархайн модуль	~ 27,000 Мра
Ус нэвчилт (ISAT)	0.002 мл / м ² / сек (хамгийн бага түвшинг хангасан)
Усны уурын тархалтын Тэсвэрлэл	μН20: 254
Нээлттэй байх хугацаа	20°C орчинд 50 – 60 минут
Үе давхрагын зузаан	Хамгийн багадаа 5 мм - Хамгийн ихдээ 30 мм
Бүтээгдэхүүний зарцуулалт	25 кг нунтаг = 13 литр зуурмаг (2,8 кг устай зуурсан тохиолдолд)
Хольцын харьцаа	1 : 9 (ус : нунтаг зуурмаг)

Хэрэглэх нөхцөлүүд

Гадаргууг бэлдэх

- Sika MonoTop 612-ийг барьцалдуулах цавуун зуурмаг болох Sika MonoTop 610-ийн дээрээс түрхэнэ. Гадаргууг Sika MonoTop 610-ийн Техникийн мэдээлэлд заасны дагуу бэлдэнэ.
- Засварлах хэсгийг тэгш өнцөгт хэлбэрээр булангийн зүлгүүрийн машинаар хамгийн багадаа 10 мм-ийн гүн ухаж бэлдэнэ.

Холих

- Гараар шавах зуурмагыг бэлдэхдээ: тохирох хувинд 2,8 литр (хамгийн ихдээ) ус хийж, нунтаг зуурмагаа дээрээс нь алгуурхан хийж бага хурдтай (минутанд 500 эргэлттэй) цахилгаан холигчоор хутгана.
- Нэгэн жигд, ямар нэгэн бөмбөлөггүй зуурмаг болтол хамгийн багадаа 3 минутын турш сайтар хольно.
- Өтгөн зуурмаг шаардлагатай тохиолдолд усны хэмжээг бага зэрэг багасгаж хийж болно.
- Шингэн зуурмагыг шүршиж хийж тохиолдолд 25 кг-ийн нунтаг зуурмагт 3,25 литр хүртэл ус хийх боломжтой. (**Санамж:** 2,8 литрээс илүү их хэмжээний ус хийх тохиолдолд зуурмагын шахалтын бат бэх буурахад нөлөөлөхийг анхааруулж байна)

Хэрэглээ

- Sika MonoTop 610 суурь цавуу наалдамхай байх үед бэлдсэн шавар зуурмагаа засварлах талбай болон нүхээ битүүлж өг. Гар шавардлагаас илүү цутгах аргачлалаар зуурмагыг хийж өгсөнөөр нүх сүв үлдэхгүй, барьцалдах боломж өндөр байна.
- Sika MonoTop 612 зуурмагаа засварын өнцөгөөс талбайн төв рүү чиглүүлэн хүчлэн шахаж тараах хэрэгтэй. 30 мм-ээс илүү гүн засварт шавардлага хийхдээ давхарлаж түрхэх шаардлагатай бөгөөд өмнө давхрагууд сайтар барьцалдаж, хатуурсан байх ёстой. Хэрэв өмнөх үе давхрагыг түрхээд 48 цаг хэтэрсэн тохиолдолд дахин давхарлахдаа гадаргууг чийглэж өгөх хэрэгтэй. Иймээс Sika MonoTop 610-ийг үе давхрага хооронд барьцалдуулах цавуу хэлбэрээр түрхэж хэрэглэнэ.
- Гадаргууг тэгш жигд болгохын тулд хамгийн сүүлийн давхрагыг төмөр нивигээр тэгшилж болно.

Цэвэрлэгээ

Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ усаар цэвэрлэнэ. Багаж дээр хатсан зуурмагыг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Анхаарах зүйлс

- Sika MonoTop 612-ийг Sika MonoTop 610 суурь түрхлэг түрхэж чийглэсэн, бат бэх гадаргуун дээр л хэрэглэх ёстой.
- Бетоны засварын ажиллагаа дууссаны дараа шаардалагайт бол гадаргууг өнгөлөх зорилгоор Sika MonoTop 620-ийг түрхэх боломжтой.
- Бетон, шавардлагын адилаар шинэ цутгасан Sika MonoTop 612-ийг бэхжилтийн үед хуурайшихаас сэргийлж арчилгаа хийх хэрэгтэй. Үүний тулд гадаргууг чийглэж, полиэпилэн гялгар хучлагаар хучих хэрэгтэй. Хэрэв давхар шавардлага хийхгүй тохиолдолд бетон бэхжилтийн бүтээгдэхүүнүүд болон Sika Antisol-ийг хэрэглэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг Sika Antisol-ийн Техникийн мэдээллийн зааварчилгаанаас үзнэ үү.
- Мэргэжлийн засварын баг чанарын өндөр түвшинд гадаргууг бэлдэж, төмөр арматурчлал болон гадаргууд жигд суурь түрхлэг түрхэж, зуурмагаа зөв хольж найруулан, цутгалт гүйцэтгэлийн ажил, арчилгааг зөв хийснээр өндөр чанартай, удаан эдэлгээтэй гүйцэтгэл болно.

Дүгнэх

- Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр

өөр байж болохыг анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт

- Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

Аюулгүй ажиллагааны заавар

Аюулгүйн техник

- Ховор тохиолдох харшилын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын бээлий өмсөж хэрэглэхийг зөвлөж байна. Амралтын цаг болон ажил дууссаны дараа бохир хувцасаа сольж гараа сайтар угаах хэрэгтэй.
- Тухайн улс, орон нутгийн Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрэм журам болон бүтээгдэхүүний савлагаан дээрх Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдтэй танилцсан байх.
- Эргэлзэх зүйл гарвал савлагаан дээрх зааварчилгааг мөрдлөгө болгох хэрэгтэй. Мөн манай Техникийн хэлтэс хандаж болно.

Чухал санамжууд

- Бүтээгдэхүүний хаягдлыг ус болон хөрсөнд хаяж болохгүй, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хаягдал устгах цэг талбайд устгана.
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон физик, хими, байгаль орчны бусад нарийн мэдээллүүд бүтээгдэхүүний Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika (NZ) Ltd
PO Box 19192
Avondale
Auckland
New Zealand

Phone: 0800 SIKA NZ 0800 745 269
Fax: 0800 SIKA FAX 0800 745 232
Email: info@nz.sika.com www.sika.co.nz



Sika®